БАТЛАВ:
"ДАРХАН УС СУВАГ"ХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.БУЯНДЭЛГЭР

"ДАРХАН УС СУВАГ"ХК-ИЙН АЖЛЫН БАЙРАНД ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн нэр, хүчин чадал	Харуул хамгаалалтын үйлчилгээ
Төсөл хэрэгжих алба, хэлтэс	"Дархан-Ус суваг"ХК, НҮА
Төсөл хэрэгжих хугацаа	2026 оны 1-р улиралд
Үндсэн хөрөнгийн код	-
Байршил	Дархан-Уул аймаг, Дархан сум, 8-р баг, 17-р хороолол, генерал Бавуугийн гудамж өөрийн байр
Хөрөнгийн ангилал	Ажил үйлчилгээ
Огноо	2026.02.02

1. **Зорилго:**

✓ Компанийн оффисын байр, спорт заал, автогражийн өөрийн өмчлөлийн хашаа бүхий газарт байрлах барилга байгууламж, эд хогшил, бараа материал, машин механизм, зам талбайд хамгаалалт, хяналт тавих.

2. **Бүрдэл:**

✓ Компанийн барилга байгууламжийн 2 цэгт оффис, автомашин механизмын 2ш автограж, спорт заал, засвар механик цех, хорогдох байр, зам талбай, авто зогсоол бүхий зурвас хашаажсан бүс газар.

3. **Техникийн үзүүлэлт**

✓ Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хоногийн 24 цагаар ээлжийн графикт ажиллах хүн хүчний нөөцтэй байх.
✓ Хариуцсан обьёктыг хамгаалах тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгсэлтэй байх ба тогтмол өмсөж хэвшсэн байх.
✓ Зам талбай, автогражид байрлах машин механизмын бүрэн байдалд хяналт тавьж хариуцна.
✓ Компанийн хашаан дотор байрлах бараа материал, эд хогшил, тоног төхөөрөмж, барилга, байгууламжийн бүрэн бүрэн байдал, тоо ширхэгт хяналт тавих.
✓ Ажлын бус цагаар автограж, механик цехийн хаалга нягтруулан хаах, дулаан алдагдлыг багасгахад анхаарч ажиллах.
✓ Онцгой хамгаалалтын дэглэмтэй бүсийн хэмжээнд хамгаалалттай байна.
✓ Хариуцсан обьёктын гадна, дотор гэрэлтүүлэгт хяналт тавьж ажиллах.

CamScanner

- ✓ Компанийн хашаа, барилга байгууламжинд нэвтрэх гадны тээврийн хэрэгсэл, хэрэглэгч, үйлчлүүлэгчийн орж гарах хөдөлгөөнд үзлэг, хяналт хийж тогтмол бүртгэл хөтөлж ажиллах. /зөвшөөрөл бүхий нэвтрэх бичгийг үндэслэн оруулах/
- ✓ Ажлын бус цагаар эргүүл үзлэг хяналтыг 2-3 цаг тутамд тогтмол хийж рапорт хөтлөн өдөр тутамд аж ахуйн менежер, бараа материалын нярав нараар баталгаажилт хийлгэнэ.
- ✓ Зөрчил илэрсэн тохиолдолд нэн даруй компанийн диспетчер инженерт мэдээллэн холбогдох арга хэмжээг авч ажиллана.

4. Чанарын шалгуур

- ✓ Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллага байна.
- ✓ Захиалагч компани нь улсын онцгой обьектын чиг үүргийг ханган ажилладаг тул түүнд хамаарах харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэгч ажилтан нь 50-аас доош насны, хөдөлгөөн, бие бялдар, хамгаалалтын чиглэлээр бэлтгэгдсэн байна.
- ✓ Тухайн ажил үйлчилгээний чиглэлээр сүүлийн 3 жилээс дээш тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуй нэгж байгууллага байна. /гэрээ, тайлангаар нотлох/

5. Бусад

- ✓ Цагдаа, шүүхийн байгууллагаас тогтоогдсон гэмт хэргийн шинжтэй хэрэгт холбогдоогүй ажилтан, албан хаагчтай аж ахуй нэгж байх. /тодорхойлолтоор нотлох/

ХЯНАСАН:

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.АЛТАНШАГАЙ

БОЛОВСРУУЛСАН:

НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА Т.ХҮРЭЛЧУЛУУН

CamScanner